ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2019 оны 05 сарын 07 өдөр Дугаар А/59. Өвт

Тээврийн хэрэгслийн албан татвар хураах, техникийн хяналтын үзлэг явуулах, жолоочийн даатгалд хамруулах ажлыг зохион байгуулах ажлын хэсэг байгуулах тухай

Авто тээврийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.3 дахь заалт, Монгол Улсын Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэг, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3 дахь хэсэг, Агаарын бохирдлын төлбөрийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.4 дэх заалт, 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэг, Жолоочийн даатгалын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. 2019 оны Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн хяналтын үзлэг явуулах, албан татвар, орон нутгийн замын санг бүрдүүлэх, жолоочийн даатгалд хамруулах ажлыг зохион байгуулах сумын ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга:Л.Батчулуун–Засаг даргын орлогч

Гишүүд: Н.Батсайхан–Татварын улсын байцаагч
З.Мягмарсүрэн-Цашдаагийгн хэсгийн дарга, Цагдаагийн хошууч
Т.Жамъянжав-1 дүгээр багийн Засаг дарга
Д.Даваацэрэн- 2 дугаар багийн Засаг дарга
С.Төмөр-3 дугаар багийн Засаг дарга
Г.Пүрэвтогтох-4 дүгээр багийн Засаг дарга
Л.Балжинням-5 дугаар багийн Засаг дарга
Ж.Батмөнх-Байгаль хамгаалагч
Н.Пүрэвтогтох-Байгаль хамгаалагч
С.Ганхүлэг-Засаг даргын Тамгын газрын ажилтан

2. Сумын ажлын хэсгийн дарга /Л.Батчулуун/-д ДААЛГАХ нь.

а. Сумын хэмжээнд Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар хураах замын санг бүрдүүлэх, даатгалд хамруулах, техникийн хяналтын үзлэг явуулах ажлыг удирдлага, зохион байгуулалтаар хангаж, хяналт тавьж ажиллах.

б. Тээврийн хэрэгсэл эзэмшигч иргэд, албан байгууллага, Аж ахуйн нэгжүүдийг үзлэгт бүрэн хамруулах ажлыг зохион байгуулах.

в. Сумын иргэдийн өмчлөлд байгаа өөр аймгийн болон Улаанбаатар хотын улсын дугаартай тээврийн хэрэгслүүдийг орон нутагт бүрэн шилжүүлж, татварын орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлэх.

г. Улсын бүртгэлд бүртгэгдээгүй, улсын дугааргүй, замын хөдөлгөөнд оролцож байгаа мотоциклыг бүртгэлд хамруулж, дугааржуулах.

0511111 47

д. Сүүлийн 5 жилд техникийн хяналтын үзлэгт хамрагдаагүй, шилжилт хөдөлгөөн хийгдээгүй, авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар төлөөгүй, улсын бүртгэлээс хасах шаардлагатай, өөрийн аймагт харьяалагдах тээврийн хэрэгслүүдийг улсын бүртгэлээс хасалт хийх ажлыг зохион байгуулах.

г. Батлагдсан хуваарь графикийн дагуу 2019 оны 05 дугаар сарын 19-өөс 05 дугаар сарын 24-ны өдрүүдэд зохион байгуулах.

3. Техникийн үзлэгийн өдрүүдэд нийгмийн хэв журмыг сахиулах, Авто тээврийн хэрэгслийн хяналтын үзлэг оношлогоонд бүрэн хамруулах ажлыг ажлын хэсэгтэй хамтран зохион байгуулахыг Цагдаагийн хэсгийн дарга, Цагдаагийн хошууч /З.Мягмарсүрэн/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА М.ЖАМЪЯНШАРАВ